



## №8.4.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

**Хяналтын байгууллага:**

**Шалгуулагч этгээдийн нэр:**

**Объектын нэр:**

**Регистрийн дугаар:**

Хяналт шалгалт хийсэн огноо: .../.../..

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

### ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	
1		2	3	4	5
<b>Цэргийн албаны бэлэн байдал</b>			<b>0</b>	<b>30</b>	<b>0</b>
1	ЦБҮАЖ-ийн 101.2.1	Улирал бүрийн нэгдсэн жагсаалын үзлэгийг тухайн байгууллагын даргын тушаал гаргаж, батлагдсан загварын дагуу тэмдэглэл хөтөлж баталгаажуулдаг	0	3	
2	ЦБҮАЖ-ийн 101.2.2	Хамгаалалтын үүрэг гүйцэтгэхийн өмнө буюу дараа зэвсэг, тусгай хэрэгслийг нэг бүрчлэн үзэж тоолдог	0	3	
3	ЦБҮАЖ-ийн 101.2.3	Албаны бэлэн байдлын зэрэглэл, жагсах газар, цаг, шалгах журам, дүрэмт хувцасны төрөл болон зэвсэг, тусгай хэрэгсэлтэй байхыг тушаалд зааж мэдээлдэг	0	3	
4	ЦБҮАЖ-ийн 101.5.2	Цагдаагийн байгууллага бүр өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах талаар төлөвлөн ажилладаг	0	2	

5	ЦБҮАЖ-ийн 101.7.2	өндөржүүлсэн бэлэн байдлын төлөвлөгөөг байгууллагын нууцад бүртгэж, битүүмжлэн хариуцлагатай зохицуулагчийн сейфэнд хадгалах ба бүртгэлээр хүлээлцдэг	0	2	
6	ЦБҮАЖ-ийн 414.3.16	Нөхцөл байдалтай уялдуулан зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтарсан төлөвлөгөөтэй	0	2	
7	ЦБҮАЖ-ийн 400.7.1	Нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулж урьдчилсан төлөвлөгөө, зураглал гаргадаг	0	2	
8	ЦБҮАЖ-ийн 414.3.1a	Жагсаал, цуглааны үүдэлтэй эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах урьдчилсан, нэгдсэн төлөвлөгөө, зураглалтай	0	2	
9	ЦДЖижүүрийн албаны заавар 3.5	Жижүүрийн офицер буюу жижүүр нь түр буюу албадан саатуулах, цагдан хорих, эрүүлжүүлэх, баривчлах байрны камеруудын бүрэн бүтэн байдал болон цагдан хорих байранд байгаа хүмүүсийг тэмдэглэл, тогтоолын дагуу нэг бҮрчлэн тулган шалгаж хүлээлцдэг	0	2	
10	ЦДЖижүүрийн албаны заавар 4.2	Жижүүр нь өргөдөл мэдээллийг элдэв шалтгаанаар хүлээн авахгүй, бүртгэхгүй өөр байгууллага албан хаагчид хандахыг зөвлөх зэргээр иргэд албан тушаалтныг чирэгдүүлэхийг хориглох ба мэдээлэл нэг бүрийг хууль тогтоомжийн дагуу шуурхай шалгаж шийдвэрлэдэг	0	3	
11	ЦБҮАЖ-ын 409.1	Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс учирч байгаа хохирлын талаар орон нутгийн засаг захиргаанд мэдээлж, холбогдох шийдвэр гаргуулан, хэрэгжүүлж буй байдал, хэрэг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажлууд зохион байгуулдаг	0	3	
12	ЦБҮАЖ-ын 409.1	Хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгслийн ажиллагааг хянах чиглэлээр үр дүнтэй ажлууд хийгддэг	0	3	
<b>Зэвсэг, техникийн хангалт, чанар, аюулгүй байдал</b>			<b>0</b>	<b>63</b>	<b>0</b>

13	ЦБҮАЖ-ын 232.2.9	Галт зэвсгийн агуулах, өрөө /сейф/-г нээх, хаах, цагийн хуваарь, нэвтрэх, гал тҮймэр гарсан үед ажиллах горимыг тушаалаар баталж хэрэгжүүлдэг	0	2	
14	ЦБҮАЖ-ын 232.2.9	Байгууллагын дарга нь зэвсэг, хэрэглэлд үзлэг хийх албан тушаалтнуудын хуваарийг гаргаж мөрдүүлдэг	0	2	
15	ЦБҮАЖ-ын 232.3.3	Галт хэрэглэл /сум/-ийг нярав биечлэн хариуцаж, гал, ус болон гадны нөлөө, халдлагаас бүрэн хамгаалагдсан зориулалтын сав /төмөр сейф/-д хадгалдаг	0	3	
16	ЦБҮАЖ-ын 232.3.6	Албаны бэлэн байдлын зэвсэг, хэрэглэлийг Цагдаагийн төв байгууллагын даргын тогтоосон тоо ширхэг /нэгж/-ийн дагуу бэлтгэж, зориулалтын сав /төмөр сейф/-д хадгалж, сумыг зориулалтын сав /төмөр хайрцаг/-д тусад нь хадгалдаг	0	5	
17	ЦБҮАЖ-ын 232.3.7	Зэвсгийн өрөө /сейф/-ний түлхүүрийг төмөр хайрцагт хийж, зэвсэг хариуцсан албан тушаалтан лацдаж, жижүүрт хадгалуулдаг	0	2	
18	ЦБҮАЖ-ын 232.3.7	Хариуцлагатай зохицуулагч /жижүүр/ нь зэвсгийн өрөө /сейф/-ний лац хүлээн авсан, хүлээлгэн өгсөн БҮртгэлийн дэвтэрийг хөтөлдөг	0	1	
19	ЦБҮАЖ-ын 232.3.8	Зэвсэг хэрэглэл хариуцагчийн эзгүй үед зэвсэг, хэрэглэлийн агуулах, өрөө /сейф/-ыг зайлшгүй онгойлгох шаардлага гарсан тохиолдолд байгууллагын даргын зөвшөөрлөөр ажлын хэсэг томилж ажиллуулах ба ажлын хэсгийн гишүүд энэ тухай нотломж үйлдэж, гарын үсэг зурдаг	0	2	
20	ЦБҮАЖ-ын 232.3.9	Хариуцлагатай зохицуулагч /жижүүр/ нь зэвсэг, хэрэглэлийг агуулах, өрөө /сейф/-г нээсэн, хаасан, гаргаж, оруулсан зэвсэг, хэрэглэл, лац, ломбо хүлээлцсэн тухайгаа хоногийн мэдээ /рапорт/-нд тусгаж, зөвхөн байгууллагын даргад, түүний эзгүйд орлож байгаа албан тушаалтанд танилцуулдаг	0	2	
21	ЦБҮАЖ-ын 232.3.10	Зэвсэг хадгалах өрөө /сейф/, зэвсгийн агуулахыг дохиолол, теле-хяналтын системээр төхөөрөмжилсөн	0	3	

22	ЦБҮАЖ-ын 232.7.1	Байгууллагын дарга нь хариуцсан байгууллагадаа данс бүртгэлтэй байгаа албаны галт зэвсэг, галт хэрэглэлийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бүртгэл, тооцооны байдалд биечлэн хяналт тавьж, жилд 2-оос доошгүй удаа Үзлэг, тооллого хийлгэдэг	0	10	
23	ЦБҮАЖ-ын 233.3.1	Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албаны зэвсэглэмжид хүлээн авч бүртгэсэн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, сумыг хэрэглэдэг	0	10	
24	ЦБҮАЖ-ын 234.3.7	Гар буунаас бусад байлдааны зориулалтын галт зэвсгийг цагдаагийн байгууллагын дарга, эсхүл тусгай бүлгийн үйл ажиллагааг удирдаж байгаа алба хаагчийн шийдвэрээр хэрэглэдэг	0	3	
25	ЦБҮАЖ-ын 235.2.1	Цагдаагийн албан хаагчид үүрэг гүйцэтгэх үедээ ашиглах найман төрлийн тусгай хэрэгсэлээр хангагддаг	0	5	
26	ЦБҮАЖ-ын 626.6.2г	Цагдаа нь эрүүлжүүлэх өрөөнд байрлагсдын аюулгүй байдалд телекамерын болон биеэр байнгын хяналт тавьдаг	0	5	
27	ЦБЖАЗ-ын 2-р хавсралт	Жижүүрт хөтлөгдвөл зохих 12 бүртгэл, бичиг баримт хөтлөгддөг	0	3	
28	ЦБЖАЗ-ын 3-р хавсралт	Жижүүр дээр байвал зохих галт зэвсэг, тусгай хэрэгсэл, нэн түрүүнд хэрэгцээтэй багаж хэрэгслүүдээр хангадаг	0	5	
<b>Сургалт</b>			<b>0</b>	<b>27</b>	<b>0</b>
29	ЦБҮАЖ-ын 125.2.2	Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, алба хаагч, ажиллагсдыг уг тоноглолыг ашиглаж сургадаг	0	2	

30	ЦБҮАЖ-ын 232.2.4	Дарга, захирагч нь алба хаагчдаа галт зэвсэг нэг бүрийн техникийн хүчин чадлыг ашиглах, эд ангийн харилцан ажиллагаа, хагас задаргаа хийх, угсрах, арчиж цэвэрлэх, буудах дадлага, чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулдаг /цагдаа нар норматив хангаж байгаа эсэхийг шалгана/	0	5	
31	ЦБҮАЖ-ын 232.4.1	Алба хаагчаас шалгалт авсны дараа даргын тушаалаар зэвсэг, хэрэглэлийг тавьж олгодог	0	2	
32	ЦБҮАЖ-ын 233.5.2	Цагдаагийн төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу олон хүнд нөлөөлөх, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтыг жилд нэгээс доошгүй, хамгаалах болон нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх сургалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулдаг.	0	5	
33	ЦБҮАЖ-ын 233.5.1	Цагдаагийн байгууллагын дарга гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэгтэй алба хаагчдыг тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамруулдаг	0	5	
34	ЦБДАД-ийн 41	Цагдаагийн байгууллага бүр гал түймрээс хамгаалах, гал гарах Үед ажиллах төлөвлөгөө боловсруулж, дарга /захирагч/ нь батлан, бие бүрэлдэхүүндээ судлуулж хэрэгжүүлдэг	0	5	
35	ЦБҮАЖ-ын 409.1	Иргэд байгуулагад хандсан замын хөдөлгөөний дүрэм, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулдаг	0	3	
<b>Цагдаагийн байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьсан байдал</b>			<b>0</b>	<b>12</b>	<b>0</b>
36	ЦБҮАЖ-ын 601	Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоодог	0	2	
37	ЦБҮАЖ-ын 602	Галт зэвсгийг бүртгэх гэрчилгээг журмын дагуу олгож, хянадаг	0	2	
38	ЦБҮАЖ-ын 605	Гэрээт, хувийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээг журмын дагуу олгож, хянадаг	0	2	
39	ЦБҮАЖ-ын 606	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавьдаг	0	2	

40	ЦБҮАЖ-ын 619	Тэнсэгдсэн ялтан, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдэд хяналт тавьдаг	0	2	
41	ЦБҮАЖ-ын 623	Захиргааны журмаар баривчлах албадан саатуулах шийдвэрийг биелүүлдэг	0	2	
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>132</b>	<b>0</b>

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: